



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/130.

Улаанбаатар хот

Мэргэжлийн дүгнэлт гаргах загвар  
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 7.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах мэргэжлийн дүгнэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, мэргэжлийн дүгнэлтийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан загварын дагуу мэргэжлийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлэн ажиллахыг Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс /Д.Даваабаяр/-т /-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын тос, бүтээгдэхүүний газар /Б.Түвшинжаргал/-т даалгасугай.

ДАРГА  БАЯРМАНДАЛ



Хөтлөх хэргийн 2/1  
Д.Цэнд-Аюуш

ГТБХ Тушаал А

53711378

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2022 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн  
1130 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах мэргэжлийн дүгнэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримт

1. Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
2. Эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар,
3. Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын баталгаажуулсан тайлан,
  - Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ангилал, төрөлд барилга байгууламжийн байршил, объектын төрөл, хүчин чадал, тухайн төсөл тус бүрийн зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зурагт хийсэн магадлалын нэгтгэсэн дүгнэлт, ажил эхэлсэн болон байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн, өгөх тухай мэдээлэл,
  - Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн барилга угсралтын ажил эрхлэх ангилал, төрөлд барилга байгууламжийн байршил, объектын төрөл, хүчин чадал, тухайн төсөл тус бүрийн батлагдсан зураг төслийн дагуу технологийн угсралт хийсэн гүйцэтгүүлэгч, зохиогчийн хамтарсан дүгнэлт, ажил эхэлсэн болон байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн, өгөх тухай мэдээлэл,
4. Мэргэжлийн инженер техникийн ажиллагсдын мэдээлэл /зөвлөх, мэргэшсэн инженерийн диплом, нийгмийн даатгалын хуулбарыг цахим системээс авсан бичиг баримт байх/,